



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 3424

Улаанбаатар хот

Аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн "Улсын бүртгэлийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай" А/176 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1."Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн бүтцийн нэгжийн орон тооны дээд хязгаар"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны "Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай" Б/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т даалгасугай.

ДАРГА




Д.ДЭЛГЭРСАЙХАН

142301175



АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
БҮТЭЦ



ооОоо

АЙМГУУДЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН БҮТЦИЙН
НЭГЖИЙН ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Албан тушаалын нэр	Орон тоо	Ангилал, зэрэглэл
2.Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтэс			
1	Дарга	1	T3-4
2	Хяналтын улсын байцаагч	1	T3-7
3	Ахлах нягтлан бодогч	1	TY-8
4	Мэдээллийн технологийн ажилтан /инженер/	1	TY-7
5	Архивч	2	TY-6
6	Бичиг хэргийн эрхлэгч, нярав	1	TY-5
2.1.Иргэний улсын бүртгэлийн тасаг			
7	Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч	1	T3-6
8	Улсын бүртгэгч	19	T3-7
2.2.Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг			
9	Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч	1	T3-6
10	Улсын бүртгэгч	5	T3-7
Нийт		33	